

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-21
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	22-103
	1.“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	22-63
	2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/	63-76
	3.Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Гадаад худалдааны бодлого, зохицуулалтын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох	76-94
	4.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газраас 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	94-97
	5.“Музейн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2020.05.01-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	97-99
	Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсгох	99-101

Хураангуй тэмдэглэл

Дөрөв.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газраас 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ш.Маяа, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Адъяа, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч О.Амартүвшин нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Б.Мажигсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 3 өдрийн завсарлага авав. /15:26/

Уг асуудлыг 15 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Дөрөв.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцууна. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг индэрт урьж байна.

Ц.Мөнх-Оргил: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2020 оны 31 дүгээр захирамжаар төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, writer.chimege.mn яриаг бичвэрт хөрвүүлэв.

дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг, Адъяасүрэн, Анужин, Баярсайхан, Ганбаатар, Жаргалмаа, Сандаг-Очир, Туваан, Чинзориг, Чинбүрэн, Энх-Амгалан нар ажилласан.

Тус Байнгын хороо 2021 оны 1 дүгээр сарын 4, 13-ны өдрүүдийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Ажлын хэсгээс Засгийн газраас нийгмийн зөвшлийн талуудтай зөвшилцөн 2018 онд өргөн барьсан хуулийн төслийн үзэл баримтлал, зарчмыг хөндөхгүйгээр Монголын Үйлдвэрчний эвлэлийнхолбоо, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын санал, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллын зөвлөмж, бусад тооцоо, судалгаанд суурилан боловсруулсан саналыг Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

Нэг.Нийт ажилтны хөдөлмөрлөх суурь эрх хангагдах бололцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтны зохистой тэнцвэрт байдлыг бий болгох чиглэлээр ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эвлэлдэн нэгдэх зэрэг суурь эрхийг хамгаалах; өдрийн болон долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаарыг тогтоох; ээлжийн амралтын үндсэн хугацааг тогтоож, тухайн байгууллагад ажилласан жил болон бусад хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг харгалзан аж ахуй нэгж байгууллага дотооддоо хамтын гэрээгээр тогтоох эрхийг хуулиар олгож, уян хатан зохицуулалт бий болгох; аж ахуйн нэгж байгууллага бүтцийн хувьд жижиг, малчид, албан бус салбарт ажиллагсдын тоо өндөр, хөдөлмөрийн харилцаанд онцлог зохицуулалтыг шаардаж байгаатай уялдуулан тэдгээрийн цалин хөлс, ажил амралтын цаг зэрэг хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хуулиар зохицуулах; хөдөлмөрийн гэрээгээр зохицуулах нийтлэг харилцаа, хөдөлмөрийн гэрээний хэлбэр, агуулга, хугацаа, хөдөлмөрийн гэрээнд шаардах бичиг баримт, гэрээнд өөрчлөлт оруулах зэрэг нөхцөлийг тодорхой болгож, хөдөлмөрийн гэрээний нэмэлт нөхцөлд сургалтын, эд хөрөнгийн, үл өрсөлдөх үүргийг нэмж тусгах, иргэд хооронд байгуулах гэрээнд тусгайлсан зохицуулалт шинээр нэмэх.

Хоёр.Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг хэрэглэхэд хялбар, тодорхой болгож, бүтэц найруулгын хувьд сайжруулах чиглэлээр “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа”, “Хөдөлмөрийн харилцаа”-г тодорхойлох, хуулийн төслийн хөдөлмөрийн харилцааны зарчимд “Нийгмийн түншлэлийг хангах”, “Хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах” гэсэн зарчмыг нэмж тусгах, хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт тогтолцоог шинэ шатанд гаргах үүднээс “Нийгмийн түншлэл” гэсэн бүлгийг шинээр нэмэх.

Гурав.Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлд анхаарч сум, дүүргийн хөдөлмөрийн маргаан зохицуулах гурван талт хорооны эрхийг өргөжүүлэх, хөдөлмөрийн эрхийн маргааныг эвлэрүүлэн зохицуулах орон тооны бус байнгын ажиллагаатай комиссыг 20 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад байгуулах зэрэг багтана.

Байнгын хорооны хуралдааны үеэр уул уурхай, олборлолтын салбарт уртын ээлжээр ажиллах ажилтны ээлжийн амралттай холбогдуулан Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний холбоо, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, Уул уурхай, хүн үйлдвэрийн яамны байр суурийг сонсож хэлэлцүүлэг өрнүүлсэн болно.

Байнгын хороо Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох хуулийн төслүүдийг мэргэжлийн Байнгын хороогоор хэлэлцүүлж санал, дүгнэлт авсан бөгөөд Хууль зүйн байнгын хороо Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд ажлын хэсэг байгуулж ажиллах шаардлагатай гэж үзсэн болно. Түүнчлэн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болж байгаатай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэж, Улсын Их Хурлын тогтоолыг боловсрууллаа.

Ажлын хэсгээс Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал, найруулгын шинжтэй санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналуудыг тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан туслах малчин зөвшөөрсөн бол түүний цалин хөлсний 30 хувиас илүүгүйг мөнгөн бус хэлбэрээр олгож болно гэснийг дэмжээгүй тул цөөнх болсон. Үүнийг Байнгын хорооны санал дүгнэлтэд тэмдэглүүлж, нэгдсэн хуралдаанд үг хэлж, саналаа илэрхийлэхээр боллоо.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хөдөлмөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аюушийн Ариунзаяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Гомбосүрэнгийн Өнөрбаяр,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баасансүрэнгийн Алимаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Шолтойн Маяа, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Хуягийн Ганбаатар, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Горчинсүрэнгийн Адъяа, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Отгондаваагийн Амартүвшин.

Горимын санал гаргая. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Хөдөлмөрийн тухай хууль 1999 оноос хойш энэ хуулийг нэлээн сайн өөрчилж чадаагүй л ингэж явсаар байгаад өнөөдрийг хүргэсэн юм билээ. Тэгээд 2018 оны 3 сарын 26-нд Засгийн газраас өргөн бариад, 2018 оны 4 сарын 10, 13-нд Байнгын хороо, чуулганаар хэлэлцэх эсэхээ шийдчихсэн ийм л хууль явж байгаа л даа. Тэгээд энэ хуулиар бол манай ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил гишүүн манай намын бүлэг дээр нэлээн сайн мэдээлэл өгч, нэлээн сайн тайлбарлаж ярьсан. Бараг л хангалттай шахуу байна. Тэгэхдээ Засгийн газраас өргөн бариад, энэ хуулийн төсөл маань Улсын Их Хурал дээр бараг 50, 70 хувь өөрчлөгдсөн юм байна. Тэгэхээр бас Засгийн газрын гишүүнийг Ардчилсан намын бүлэг дээр орж ирж энэ талаар нэлээн сайн нягталж ярилцах ёстой гэж үзэж байгаа. Энийгээ 1 дэх өдөр хийнэ.

Тийм учраас бас сүүлийн үед ялангуяа манай нам бол чөлөөт өрсөлдөөн, зах зээл, хувийн өмч, энэ бүхнийг дэмждэг ийм нам. Тэгээд ажил олгогчдодоо нэлээн хатуурхсан ийм зүйл заалтууд байна уу гэдгийг бид нар нягтлах ёстой гэж үзэж байгаа. Ингээд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн төслийн хэлэлцэх асуудлаар 3 хоногийн завсарлага авч байна.

Г.Занданшатар: 3 хоногийн завсарлага өглөө.

3 дахь өдөр хүртэл. 3 дахь өдөр чуулган хуралдаж магадгүй гэж бодож байна. 1 дэх өдөр бүлгээрээ сайн ярилцчих.

Дараагийн асуудалд орно.